



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Гашуунсухайт дахь гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9,600,000.00 (есөн сая зургаан зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 7,207,399.90 (долоон сая хоёр зуун долоон мянга гурван зуун ерэн есөн төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Т.Жаргалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000079

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн
52... дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа Гашуунсухайт дахь гаалийн газрын балансаас
"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн балансад
шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэм жиж нэгж	Тоо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
8	Гадна цахилгаан ШНЦ	2015.01.01	ш	1	9,600,000.00	7,207,399.90	2,392,600.10	"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК
				1	9,600,000.00 (есөн сая зургаан зуун мянган)	7,207,399.90 (долоон сая хоёр зуун долоон мянга гурван зуун ерэн есөн төгрөг ерэн мөнгө)	2,392,600.10 (хоёр сая гурван зуун ерэн хоёр мянга зургаан зуун төгрөг арван мөнгө)	